



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/364

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 60.1.2 дахь заалт, 60.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, газрын доройтол, хөрсний эвдрэлийг бууруулах зорилгоор Алтай сумын Бодонч багийн Ендэрт хэмээх 3 га газарт хийсэн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: А.Ганцоож - Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

Гишүүд: Х.Түмэндэлгэр - Алтай сумын Засаг дарга  
Н.Алтанцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

П.Даваасүрэн - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн


С.Долгормаа - Алтай сумын байгаль орчны улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл - Алтай сумын газрын даамал

Нарийн бичгийн

дарга: Б.Ариундолгор - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Хоёр: Захирамжийн хэрэгжилтийг хангаж, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга (А.Ганцоож)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 ah-1846